



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 143

Улаанбаатар хот

Мэргэжлийн баг байгуулах тухай

“Монгол улсын засгийн газрын 2012 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан “Эрүүл хүүхэд” аяны хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь :

1. Эрүүл хүүхэд аяны хүрээнд зохион байгуулж буй хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах, шүд цооролтын тархалтыг зогсоох чиглэлээр хийгдэх оношлогоо, эмчилгээний асуудлыг улсын хэмжээнд мэргэжил арга зүйгээр хангаж, хяналт тавих чиг үүрэг бүхий мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, “Шүд цооролт өвчний эмнэл зүйн удирдамж”-ийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. “Шүд цооролт өвчний эмнэл зүйн удирдамж”-ийн талаарх сургалтанд шүдний мэргэжилтнүүдийг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулахыг аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Мэргэжлийн багийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Гончигсүрэн)-т даалгасугай.

САЙД

Н.ХҮРЭЛБААТАР

130

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
...4...дугаар сарын 27...ний өдрийн...18...тоот
тушаалын нэгдүгээр хавсралт

Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах, шүд цооролтын тархалтыг зогсоох чиглэлээр хийгдэх оношлогоо, эмчилгээний асуудлыг улсын хэмжээнд мэргэжил арга зүйгээр хангаж, хяналт тавих чиг үүрэг бүхий мэргэжлийн багийн бүрэлдэхүүн

Дарга:

Б.Амарсайхан - Нүүр ам судлалын сургуулийн захирал, Анагаах ухааны доктор, профессор, Азийн нүүр амны у/с академийн ерөнхийлөгч

Нарийн бичгийн дарга:

Я.Буянжаргал – Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн

Гишүүд:

Г.Соёлгэрэл - Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн

Б.Оюунцэцэг - Нүүр ам судлалын сургуулийн хүүхдийн хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлтийн тэнхмийн эрхлэгч, Анагаах ухааны доктор

Д.Чухал - Нийслэлийн Шүд эрүү нүүрний эмгэг судлалын төвийн захирал

Б.Оюунбат - Нүүр ам судлалын сургуулийн эрдэм шинжилгээний институтын захирал, Монголын шүдний мэргэжилтнүүдийн холбооны ерөнхийлөгч, Анагаах ухааны доктор, профессор

М.Соёлмаа - Нүүр ам судлалын сургуулийн шүд эрүү нүүрний эмнэлгийн дарга, Анагаах ухааны доктор

Я.Хулан - Нүүр ам судлалын сургуулийн эмчилгээний тэнхмийн эрхлэгч, АУ доктор

Л.Мөнгөнцэцэг - Нүүр ам судлалын сургуулийн нүүр амны эрүүл ахуйн тэнхмийн эрхлэгч Анагаах ухааны доктор, профессор

Л.Батмөнх - Шүдний бизнес эрхлэгчдийн холбооны ерөнхийлөгч

131

Эрүүл мэндийн сайдын 2012 оны
...дүгээр сарын 27-ний өдрийн /УЗ/
тоот тушаалын хоёрдугаар
хавсралт

ХҮҮХДИЙН ШҮД ЦООРОХ ӨВЧНИЙГ ЭМЧЛЭХ УДИРДАМЖ


Шүд цоорох өвчин нь олон шалтгаант халдварт өвчин бөгөөд үүсч даамжирснаар эрхтэн тогтолцооны өвчин эмгэгүүдийн шалтгаан болдог. Иймд шүд шүдлэх үед цоорлоос сэргийлэх арга хэмжээ авах түүнчлэн эрт үед нь илрүүлэн эмчлэх нь хатуу эдэд гарсан эмгэг өөрчлөлтийг зогсоож, тухайн шүдний анатомын хэлбэр, гоо зүй, үйл ажиллагааг нөхөн сэргээж, шүд цоорох өвчний хүндрэл болох зөөлцийн ба холбоосын үрэвсэл, идээт үрэвслүүд, эрүү, шүдний гажгаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Хүүхдийн байнгын их араа буюу 1 дүгээр араа шүдийг цоорлоос сэргийлэхийн тулд тухайн шүдийг шүдэлмэгц шүдний ховилыг зориулалтын материалаар битүүлэх буюу сийлант тавих аргаар цоорол үүсэхээс сэргийлдэг.

Сүүн шүдний цоорлыг эрт үед нь цоорлыг зогсоох арга буюу сафорайд түрхэх аргаар цоорлыг зогсоож эмчилдэг.

Түүнчлэн хүүхдийн шүдний цоорлыг шүдийг өрөмдөхгүй ломбодох арга хэргэлэн ломбодох хамгийн энгийн үр дүнтэй аргад тооцогддог.

I. Шүдний ховил хаах буюу битүүлэх арга- Сийлант тавих



Зориулалт: Шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор араа шүднүүдийн төрөлхийн ховил, хонхорыг зориулалтын материалаар битүүлж хаах арга юм. Зөвхөн ховил битүүлэхээс гадна фтор агуулсан байдаг учир шүдний хатуу эдийг бэхжүүлдэг. Гэрлээр болон өөрөө хатуурдаг 2 янз байдаг.

Хэрэглэгдэх багаж:

Үзлэгийн цомог амны толь, хямсаа, сэтгүүр, ариун бээлий, гэрлийн аппарат, өнгөлгөөний бор болон чулуу, резин

Материал: Хөвөн бөмбөлөг, ам ариутгах уусмал

Заалт: Байнгын араа шүднүүдийн төрөлхийн хонхор ховил битүүлэх

Эсрэг заалт: Шүд цоорсон бол хэрэглэж болохгүй.

Сийлант тавих арга техник:

1. Тухайн шүдийг маш сайн угааж цэвэрлэж өнгөргүй болгосон байна.
 2. Ариутгалын уусмалаар амыг зайлуулах, тухайн шүдээ хөвөн бөмбөлгөөр сайтар цэвэрлэж арчина.
 3. Шүлснээс тусгаарлана. \Хөвөн ороомогоор\
 4. Хөвөн бөмбөлгөөр буюу машины үлээгчээр тухайн шүдээ хатаана.
 5. 30-33%-ын Ортофосфорын хүчлээр ховил дагууд багсаар болон зориулалтын шприцтэй хүчлийг зүүн хошуугаар дагуулан нимгэн цувуулж түрхэнэ.
 6. 20-40 секунд болсны дараа хүчлээ даралттай усаар 10-15 секундын турш шүршиж угаана.
 7. Шүлснээс тусгаарлана. \Хөвөн ороомогоор\ Зөөлөн үлээлгэж хуурайшуулна.
 8. Зориулалтын шприц бүхий Сийлантыг ховил дагуу цувуулан хийгээд үзлэгийн сэтгүүрээр ховилуудад зурж чигжиж, жигдрүүлэн тараана. Аль болох зуулт өндөрсгөхгүйгээр байхыг анхаарна.
 9. Гэрлийн аппаратын тусламжтай 40 – 60 секунд шарж хатууруулна.
 10. Шүдний хоршилтийг хазуулж үзэхээс гадна хар цаас зуулган шалгаж үзнэ. Хэрэв зуухад өндөр буюу түрүүлж хоршиж байвал өнгөлгөөний чулуугаар намсгаж тохируулаад резинэн өнгөлөгчөөр өнгөлнө.
- Жич: Хаанаас ямар компаний үйлдвэрлэсэн материал авсан түүнийхээ зааврыг сайн харах хэрэгтэй.

1.

II. Сүүн шүдний цоорлыг зогсоох арга (Сафорайд-Saforide)

1. Хэрэглэгдэх багаж: Үзлэгийн ариутгасан цомог багаж - толь, хямсаа, сэтгүүр, ломбоны багажууд, шүлс сорогч, жижиг багс буюу спонж, ариутгасан бээлий

2. Материал: Ариутгасан хөвөн бөмбөлөг, ариутгалын уусмал, Сафорайд /Saforide нь 5 мл-ээр тусгайлан бэлдсэн саванд савлагдсан, өнгөгүй уусмал /

3. Эмчилгээний заалт:

- Сүүн шүдний өнгөц цоорол
- Сүүн шүдний дунд цоорол

4. Эмчилгээний эсрэг заалт:

Сүүн шүдний өнгөц ба дунд цоорлоос бусад бүх тохиолдол

АНХААР : Хүүхдийн зөвхөн сүүн шүдэнд хэрэглэнэ.

5. Хийх арга, техник

- Шүдийг өнгөрөөс цэвэрлэнэ.
- Шүлснээс тусгаарлана.
- Бусад шүд, буйл, салстыг сайн тусгаарлаж хамгаална. Шүлс их ялгарах үед шүлс сорогчийг хэрэглэнэ.
- Агаараар үлээж шүдийг хуурайшуулах, тухайн шүд орчмын буйл салстыг хөвөн эсвал самбайгаар тусгаарлана.
- Шүдний зөөлөрсөн тугалмайн эдийн хэсгийг зөвхөн өнгөрөөс цэвэрлэнэ.
- Жижиг багс буюу спонжид сафорайдыг (0,15мл-ээс 0,2мл) шингээж тухайн цоорлын хэсэгт жигд түрхэн, гэрлийн аппаратаар 15-20 секунд шарна . Тухайн түрхсэн хэсэгт шүдний өнгө хувирч, хар өнгөтэй болно.
- 1 сарын дараа шалгаж үзнэ. Хэрвээ тухайн хэсэг хатуураагүй бол дахин түрхэнэ. Хатуурсан тохиолдолд цоорол зогссон гэж үзнэ.

Анхаарах зүйл, гарч болзошгүй хүндрэл:

- Онош буруу тавигдсанаас өвдөлт өгөх, зөөлцийн болон холбоосын үрэвсэл үүсэх
- Гашуун амттай тул хүүхдийн буйл салстад хүрэлцэхээс сэргийлэх

III . Шүдийг өрөмдөхгүй ломбодох арга (ART)

А. Хэрэглэгдэх багаж:

1. Үзлэгийн толь



Зураг 1

- 2.

3. Зонд




Зураг 2

4. Хямсаа



Зураг 3

5. Экскаватор



Зураг 4

6. Хатчет (паалангийн ирмэгийг авах хурц иртэй багаж)




Зураг 5

7. Гладилка



Зураг 6

8. Материал зуурах цаас, шпатель



Зураг 7

В. Шаардлагатай материал:

1. Гласс-иономер (Fuji IX)



Зураг 8

2. Шүлснээс тусгаарлах хөвөн



Зураг 9

3. Хөвөн бөмбөлөг

4. Вазелин


5. Гялгар матрикс

С. Эмчилгээний заалт:

1. Өнгөц цоорол (Зураг А)
2. Дунд цоорол (Зураг В)

Д. Эсрэг заалт:

1. Гүн цоорол
2. Шүдний зөөлцийн үрэвсэл (Зураг С)
3. Шүдний холбоосын үрэвсэл (Зураг D)



Зураг 10. Цоорол, түүний хүндрэл

Е. Цоорлын хөндийг бэлтгэж, ломбодох арга техник:

1. Хэрэв цоорлын хөндийн амсар жижиг бол хатчетаар томсгоно.



Зураг 11


2. Цоорлын хөндийн хана, ёроолыг хатуу болтол зөөлөрсөн тугалмайг экскаватороор авна.




Зураг 12

3. Шүдийг шүлснээс тусгаарлана.
4. Цоорлын хөндийг халдваргүйжүүлнэ.
5. Цоорлын хөндийг хатаана.
6. Гласс-иономер материалыг үйлдвэрлэгчийн зааврын дагуу цаасан дээр хуванцар шпателиар 20-30 сек зуурна.

7. Зуурсан материалыг гладилкаар авч цоорлын хөндийд хийнэ. Цоорол түшилцэх гадаргыг хамарсан бол матрикс тавьж ломбодоно (Зураг 13, 14).



Зураг 13. Үүдэн шүдэнд матрикс байрлуулсан байдал
шүдэнд матрикс байрлуулсан байдал



Зураг 14. Араа

8. Долоовор хуруунд (бээлийтэй) вазелин түрхэж ломбоны дээрээс хэдэн сек дараад хажуу тийш гулгуулж авна.
9. Илүүдэл материалыг дунд буюу том хэмжээтэй экскаватороор авна.
10. Материалыг хатууртал 1-2 мин хүлээнэ.
11. Хоршилт тааруулна.
12. Ломбыг шүлснээс тусгаарлан вазелин түрхэнэ.
13. Өвчтөнд 1 цаг идэж, уухгүй байхыг зөвлөнө.



Зураг 15. Цоорлын хөндийг ломбодож буй байдал